



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/525

Ховд

Хүүхдийн парк доторх тохижилт /Сурагч хөшөө/-ын
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Батдайчин” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хүүхдийн парк доторх тохижилт /Сурагч хөшөө/-ын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд: Ц.Цолмонбаатар	- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Д.Отгонтуяа	- “Мянган угалзат” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн Архивын тасгийн дарга
Б.Очирбат	- “Батдайчин” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. “Батдайчин” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН